

"ХААН ДААТГАЛ" ХХК

1. Даатгуулагч болон зөвшөөрөгдсөн этгээдийн доорхи үйлдлээс үүдсэн хохирол. Үүнд:
 - 1.1 Тээврийн хэрэгслийг согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ жолоодох эсхүл гэмт хэрэг үйлдэх зорилгоор хууль бусаар ашигласнаас үүдэн гарсан хохирол;
 - 1.2 Тээврийн хэрэгслийг болон түүний эд ангийг зориулалтын бусаар ашигласан, даац ачаалал хэтрүүлсэн, ашиглалтын горимыг өөрчилснөөс үүдэн гарсан хохирол;
 - 1.3 Ан ав хөөх болон уралдааны зориулалтаар ашиглаж явсанаас үүдсэн хохирол;
 - 1.4 Зориулалтын бус аргаар тээврийн хэрэгслийг халаах, асаах; /Үүнд: Моторыг доороос болон дээрээс бамбардах, машины доогуур гал түлэх, газ болон паяльникаар моторыг халаах зэрэг/
 - 1.5 Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй; /Үүнд: Тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос эвдэрсэн, хол, ойрын болон ар талын оврын гэрлүүд асахгүй болсон, жолоочийн талын шил арчуур ажиллахгүй болон зам тээврийн ослын үед ослын гэрэл асааж, тэмдэг тавиагүй/
 - 1.6 Жолоодох эрхийн үнэмлэхгүй, жолоодох эрх нь хасагдсан, зам тээврийн ослын хэрэг нь шүүх прокурор болон замын цагдаагийн байгууллага дээр хянагдаж байгаа жолоочийн учруулсан хохирол;
 - 1.7 Даатгагч болон замын цагдаагийн байгууллагад ослын талаар мэдэгдэлгүйгээр тэдний зөвшөөрөлгүйгээр ослын газраас хөдөлж ослын ул мөрийг балласан бол;
 - 1.8 Даатгалтай тээврийн хэрэгслийг бусад барьцаалуулах, түрээслүүлэх болон ашиглуулах үед учирсан аливаа хохирол;
2. Даатгалын зүйлийн доорхи эд ангид учирсан хохирол. Үүнд:
 - 2.1 Ердийн элэгдэл, хорогдол болон механик эвдрэл, мотор цохих;
 - 2.2 Дугуйн гадуур бүрээс, олгойнд учирсан хохирол;
 - 2.3 Даатгуулагч нэмэлт тоноглол хэрэгслээ даатгаагүй үед нэмэлт тоноглолд учирсан хохирол;
 - 2.4 Ашиглалтын хугацаа заасан эд ангиуд болон туслах, дагалдах материалууд болон тэдгээрээс үүдэлтэй хохирол;
 - 2.5 Үйлдвэрлэлийн дефектээс болон буруу суурилуулсан, угсарсан, задалсанаас үүдэн гарсан болон тэдгээрийг засварласан аливаа зардал;
 - 2.6 Даатгуулагчийн сонгосон хамгаалалтанд хамаарахгүй болон сонголтоор нэмж даатгуулагчий эрсдлээр учирсан хохирол түүний үр дагавар;
 - 2.7 Даатгалтай тээврийн хэрэгслийг тээвэрлэх үед гарсан хохирол болон дотор байсан эд зүйл, тээвэрлэж явсан ачаанд учирсан хохирол;
3. Нийгмийн шинж чанартай доорхи эрсдлүүдээс учирсан хохирол. Үүнд:
 - 3.1 Дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, мина хаях, атомын болон цөмийн дэлбэрэлт, бөмбөг дэлбэлэх
 - 3.2 Нийгмийн эмх замбраагүй байдал, зэвсэгт халдлага, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
4. Нөхөн төлбөр олгохгүй бусад нөхцөл
 - 4.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нөхөн төлбөрийн материалыг 45 хоногийн дотор /даатгалын тохиолдол болсноос хойш/ бүрдүүлж өгөөгүй бол;
 - 4.2 Бусад учруулсан хохирол;
 - 4.3 Гэрээгээр тохиролцсоноос бусад эрсдлийн улмаас даатгалын зүйлд учирсан хохирол болон гэрээнд заагаагүй нэмэлт зардал;
 - 4.4 Даатгалын үнэлгээнээс хэтэрсэн хохирол болон даатгалын тохиолдол болсныг тухайн үед нь нотлоогүй буюу нотлох боломжгүй болсон бол;
 - 4.5 Хуульд заасан бусад үндэслэл.